



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2023 оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

**“Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-д
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-д дор дурдсан агуулга бүхий 5.4.3 дахь заалтыг нэмсүгэй.

1/ Журмын 5.4.3 дахь заалт;

“5.4.3. Даатгалын зуучлалын үйл ажиллагаандаа хууль, журам болон даатгагчтай хамтран ажиллах гэрээг зөрчсөнөөс үүдэн даатгуулагч эсхүл даатгагч хохирсон бол Хорооноос даатгалын зуучлагчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.”

2. Мөн журмын 3.5 дахь хэсгийн “боловсруулсан” гэсний өмнө “энэ журмын ... дүгээр хавсралтад заасны дагуу” гэж, 3.7 дахь хэсгийн “сар” гэсний өмнө “нэг удаа эсхүл” гэж, 3.11 дэх хэсгийн “хэмжээг” гэсний дараа “Хороонд бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний хураамжийн тооцоололд үндэслэн” гэж, 4.4 дэх хэсгийн “үйл ажиллагаа” гэсний өмнө “зуучлалын” гэж тус тус нэмсүгэй.

3. Мөн журмын 1, 2, 3 дугаар хавсралтыг энэ тогтоолын хавсралтаар, 2.2 дахь хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай.

1/ Журмын 2.2 дахь хэсэг;

“2.2. Урт хугацааны даатгагч нь зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалаар энэ журмын ... дүгээр хавсралтад зааснаас бусад аливаа шалтгааны улмаас даатгуулагч нас барах болон хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдах үндсэн эрсдэлийг даатгана.”

4. Мөн журмын 3.1 дэх хэсгийн “зээл олгох үед тухайн зээлийн хэмжээ, даатгалын гэрээг сунгах үед тухайн” гэснийг “даатгалын гэрээ байгуулах” гэж, 3.5 дахь хэсгийн “Даатгагч” гэснийг “Ердийн даатгагч” гэж, 3.8 дахь хэсгийн “Даатгалын” гэснийг “Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын” гэж тус тус өөрчилсүгэй.

5. Мөн журмын 3.7 дахь хэсгийн “Урт хугацааны даатгалын хувьд даатгалын хураамжийг нэг удаа бүрэн төлж болно.” гэснийг хассугай.

6. Мөн журмын 2.2.1, 2.2.2, 3.4.1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН